

“Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 02 сарын 16 өдрийн хурлын
06/2023 дугаар тогтоолын хавсралт

БАТЛАВ. ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.ЗОРИГТ

“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН АУДИТЫН ХОРООНЫ ЖУРАМ

НЭГ. ЗОРИЛГО

1.1 ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны зорилго нь:

- 1.1.1 Байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа
- 1.1.2 Санхүүгийн тайлагналын үнэн зөв, бодит байдал
- 1.1.3 Компанийн дотоод хяналт, журмуудыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал
- 1.1.4 Эрсдлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдлийн удирдлагын хэрэгжилтэнд хяналт тавих
- 1.1.5 Хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох

зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар ТУЗ-ийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

ХОЁР. ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

2.1 Аудитын хороо нь ТУЗ-ийн гишүүдийн саналаар сонгогдож, хурлаас томилогдсон 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх ба хорооны дарга нь хараат бус гишүүн байна.

2.2 Хорооны гишүүд нь санхүү, эдийн засгийн боловсрол, туршлагатай байх бөгөөд санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хүрээнд “санхүүгийн шинжээч” байна.

ГУРАВ. ХУРАЛ

3.1 Хорооны хурал жилд 1-ээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зохион байгуулж болно.

3.2 Хуралд гишүүдийн 2/3 –оос доошгүй нь оролцох бөгөөд биечлэн оролцох боломжгүй бол гишүүн бүр саналаа илэрхийлэх боломж бүрдүүлсэн техник хэрэгсэл ашиглан хурлыг зохион байгуулж болно. Эсвэл бичгээр саналыг нь авч болно.

3.3 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг урьдчилан гаргуулж гишүүн бүр танилцсаны үндсэн дээр хэлэлцэнэ.



3.4 Хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлага, ажилтнууд, гаднын зөвлөгчид, аудитор оролцож болно.

3.5 Хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, зөвлөмж, удирдамж гаргаж, холбогдох дүрэм, журам батална.

ДӨРӨВ. ХОРООНЫ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛУУД

4.1 Хяналтын тогтолцоог бүрдүүлэх

Хороо нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны бүх хүрээг хамарсан хяналтын тогтолцоог бүрдүүлнэ. Хяналтын тогтолцоо нь чадварлаг, шуурхай, мэргэшсэн, хараат бус байх ба компанийн зохистой ажиллагаа, үр ашгийг нэмэгдүүлэхэд бодьтой хувь нэмэр оруулж, эрсдлээс сэргийлж чаддаг байна. Үүнд:

4.1.1 Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах хөндлөнгийн аудиторт шалгуур үзүүлэлтүүдийг тогтоож, хараат бус аудиторын эрх, үүрэг, хариуцлага, төлбөр зэрэг гэрээний нөхцлийн талаар саналаа боловсруулан ТУЗ-өөр шийвэрлүүлнэ.

4.1.2 Хараат бус аудиторын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаад дүгнэлт хийн дүгнэлт гаргаж, ажлын гүйцэтгэлийг үнэлэн гэрээг батална.

4.1.3 Компанийн удирдлага, ажилтнуудын зүгээс хараат бус аудиторын зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавина.

4.1.4 Компанийн дотоод аудитын үйл ажиллагаа, цалин хөлс, төсөв зэргийг тодорхойлох, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг үнэлэх, зөрчлийн арилгах, урьдчилан арга хэмжээ авна.

4.2 Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих

4.2.1 Компанийн гадаад, дотоод хяналтын тогтолцоогоор дамжуулан, дүгнэлт гаргах, гарсан зөрчлийг арилгах талаар компанийн удирдлагад үүрэг чиглэл өгөх, ТУЗ-д тайлагнах ажлуудыг хийнэ. Үүнд:

4.2.2 Санхүүгийн үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлагнал нь олон улсын стандартад нийцэж байгаа эсэх, санхүүгийн талаар хийгдсэн аливаа шалгалт, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа байдал зэрэгт хяналт тавина.

4.2.3 Санхүүгийн удирдлага зохистой байгаа эсэх, гэрээ хэлцлийн сонирхлын зөрчилгүй байдал, зээлийн эргэн төлөлтөнд нөлөөлөхүйц байдал зэргийг хянана.

4.2.4 Мэдээллийн ил тод байдал хангагдаж буй эсэх, компанийн нууц алдагдсан болон буруугаар ашиглагдсан эсэхийг хянана.



4.2.5 Компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны зохистой байдал, хууль дүрэм, ёс зүйн хэм хэмжээг баримталж байгаад хяналт тавьж, алдаа дутагдлыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авах

4.3 Эрсдлийн удирдлагын үйл ажиллагаа

Эрсдлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, хэрэгжилтэнд хяналт тавих, тогтолцоог бий болгох, үйл ажиллагааны зохин байгуулалт, төлөвлөгөөг батлах, шаардлагатай удирдамж чиглэлийг өгөх зэрэг ажлыг хийнэ.

4.4 Тайлагнах, нууцыг хадгалах үүрэг

4.4.1 Аудитын хороо нь үйл ажиллагаагаа ТУЗ болон ХЭХ-д тайлагнана.

4.4.2 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол дүгнэлтийг ХЭХ-д танилцуулна.

4.4.3 Хорооны гишүүд чиг үүргээ биелүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан, эсвэл шалгалтаар илэрсэн аливаа нууц мэдээллийг хувийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх, шууд болон шууд бус хэлбэрээр бусдад задруулахгүй, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэг хүлээнэ.

5. ХОРООНЫ ЭРХ МЭДЭЛ

5.1. Хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараахь эрхтэй байна. Үүнд:

5.1.1 Хараат бус аудитын байгууллагыг томилох, төлбөрийн хэмжээг тогтоох, ажлыг нь шалгах, гэрээг цуцлах

5.1.2 Дотоод аудитыг томилох, цалин урамшууллын хэмжээг тогтоох, шалгалтын ажил даалгах, гүйцэтгэлийг үнэлэх, ажлаас чөлөөлөх

5.1.3 Шаардлагатай нөхцөлд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах

5.1.4 Эрсдлийн удирдлагын бүрэлдэхүүнийг томилох, үүрэг даалгавар өгөх

5.4.5 Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил гаргасан үед арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай үед гүйцэтгэх ажилтны эрхийг түдгэлзүүлэх саналаа ТУЗ-д оруулах

5.4.6 Энэхүү дүрмийн заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл, ТУЗ-д санал оруулан батлуулах

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ